



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 37,588,136.30 (гучин долоон сая таван зуун наян найман мянга нэг зуун гучин зургаан төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга П.Дэлгэрнаранд дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулан бүртгэх;

2.3. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу төрийн өмчит үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.Гаваа Б.ГАВАА



0002051



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 113 Дугаар тогтоолын хавсралт

**"Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэх өртөг (төгрөгөөр)	Сэргээн босголтын зардал (төгрөгөөр)	Худалдах доод үнэ (төгрөгөөр)
1	УАЗ-22069 маркийн, 61-56 УБӨ улсын дугаартай, Арлын дугаар - 704727758	2004/2004	107002	16,935,636.30	16,935,636.30	0.00	7,662,600.00	7,500,000.00
2	УАЗ-211697 маркийн, 87-90 ӨВА улсын дугаартай, Арлын дугаар -	2001/2001	102378	15,152,500.00	15,152,500.00	0.00	2,800,000.00	2,500,000.00
3	Ниссан Санни маркийн, 52-00 ӨВА улсын дугаартай, Арлын дугаар -EB15020791	1999/2008	212200	5,500,000.00	5,500,000.00	0.00	1,800,000.00	2,500,000.00
				<b>37,588,136.30</b>	<b>37,588,136.30</b>	<b>0.00</b>	<b>12,262,600.00</b>	<b>12,500,000.00</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>			37,588,136.30 (гучин долоон сая таван зуун наян найман мянга нэг зуун гучин зургаан төгрөг гучин мөнгө)	37,588,136.30 (гучин долоон сая таван зуун наян найман мянга нэг зуун гучин зургаан төгрөг гучин мөнгө)		12,262,600.00 (арван хоёр сая хоёр зуун жаран хоёр мянга зургаан зуун)	<b>12,500,000.00</b> (арван хоёр сая таван зуун мянган)